ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ТӨХХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/104/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261628 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "ЦЭБЭ Консалтинг аудит" ХХК-ийн Захирал: Д.Энхбаатар
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Улаанбаатар хот
2024 он

Scanned with MOBILE SCANNER

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан 4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 5
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл 6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа 8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин 8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт 9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл 11
4. АУДИТЫН ТАЙЛАН 12
4.1 Ерөнхий зүйл 12
4.2 Материаллаг байдал 12
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 12
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт 13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 13
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд 13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 14
4.5.1 Завсрын аудитын талаар 14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн 14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 14
5.1 Албан шаардлага 14
5.2 Зөвлөмж 15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 16
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 16
6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани

Scanned with MOBILE SCANNER

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/724

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЭРДЭНЭБУЛГАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 82,708.8 сая төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Олон жилийн насжилттай, 21,407.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Өр төлбөрийн үлдэгдэлд тусгагдсан 37 аж ахуйн нэгж, 1,540 иргэнд төлөх нийт 30,641.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Шүүхийн шийдвэрээр Хөгжлийн банканд төлөх 25,649.9 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 дахь заалтуудтай нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага тайлант онд 5,002 айлын 9 давхар 67 блок орон сууц бүхий "Солонго-1,2" орон сууцны цогцолбор хорооллыг Монгол Улсын Засгийн газар болон

0001051479
MOBILE SCANNER

БНСУ-ын Экспорт импорт банкны хооронд байгуулсан 266.9 сая ам.долларын зээлийн санхүүжилтийн гэрээгээр барих төслийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр "Колон глобал корпорашн" ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Засгийн газрын 2016 оны "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 38, 169 дүгээр тогтоолуудад Төрийн орон сууцны корпорац ТӨХХК-ийн захиалгаар Улаанбаатар хот болон орон нутагт барьж ашиглалтад оруулсан 1,289 айлын орон сууцны барилгыг барихад зарцуулсан Хөгжлийн банкны зээлийн төлбөр болох 82,344.9 сая төгрөгийг улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусган шийдвэрлэхээр заасан байна. Төрийн орон сууцны корпорац ТӨХХК нь Хөгжлийн банкны зээлийн үндсэн төлбөрт төлөхөөр 6 жилийн хугацаатай, хүүгүй дамжуулан зээлдүүлэх гэрээг Барилга, хот байгуулалтын яамтай байгуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх зээлийн санхүүжилтийн эх үүсвэрт жил бүр 5,000.0 сая төгрөгийг тусгаж, 2019-2023 онуудад нийт 25,000.0 сая төгрөгийг зээлж, гэрээнд заасны дагуу зээлийн эргэн төлөлтийг Сангийн яамны Төрийн сан банкны төсвийн орлогын дансанд хуваарийн дагуу төлж, 22,000.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд орлогыг 22,176.4 сая төгрөгөөр, зардлыг 22,169.7 сая төгрөг, ашгийг 5.8 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 13,853.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 18,919.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, Солонго-1,2 төсөл хэрэгжээгүйгээс шалтгаалж 13,833.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК нь 2023 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 30 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 92.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Scanned with MOBILE SCANNER

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Scanned with MOBILE SCANNER

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон */ төгрөгөөр/*

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	**Эргэлтийн хөрөнгө**		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,772,404,139.58	4,575,957,777.52
1.1.2	Дансны авлага	53,110,058,644.72	52,002,996,859.24
1.1.3	Татвар, НДШимтгэлийн авлага	3,845,470.83	4,430,103.21
1.1.4	Бусад авлага	207,163,890.29	207,163,890.29
1.1.6	Бараа материал	10,746,075,679.94	11,314,465,171.42
1.1.7	Урьдчилж төлсөн зардал / тооцоо	5,161,638.35	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгө	88,664,294,763.89	88,374,179,646.22
1.1.20	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**164,509,004,227.60**	**156,479,193,447.90**
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,032,276,226.24	972,053,366.83
1.2.2	Биет бус хөрөнгө	67,525,938,440.06	67,545,438,436.66
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000,000.00	1,000,000.00
1.2.20	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**68,559,214,666.30**	**68,518,491,803.49**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**233,068,218,893.90**	**224,997,685,251.39**
2	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**		
2.1.1	**Богино хугацаат өр төлбөр**		
2.1.1.1	Дансны өглөг	57,827,484,738.46	56,291,447,035.86
2.1.1.2	Цалингийн өглөг	-	815,584.14
2.1.1.3	Татварын өр	695,780,726.88	31,049,726.58
2.1.1.6	Хүүний өглөг	462,376,712.32	462,376,712.32
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	7,548,018,953.23	11,089,768.020.51
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**66,533,661,130.89**	**67,875,457,079.41**
2.1.2	**Урт хугацаат өр төлбөр**		
2.1.2.1	Урт хугацаат зээл	25,021,605,754.60	24,629,279,556.37
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	198,700,000,028.49	202,500,000,028.49
2.1.2.5	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**223,721,605,783.09**	**227,129,279,584.86**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**290,255,266.913.98**	**295,004,736,664.27**
2.3	**Эздийн өмч**		
2.3.2	Өмч: – төрийн	88,000.00	88,000.00
2.3.4	Нэмж төлөгдсөн капитал	17,000,270.98	17,000,270.98
2.3.7	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	60,328,787.00	60,328,787.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	66,698,133,880.00	66,698,133,880.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(123,962,598,958.06)	(136,782,602,350.86)
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**(57,187,048,020.08)**	**(70,007,051,412.88)**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**233,068,218,893.90**	**224,997,685,251.39**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ САНААТ ДУНЗЭМ
Scanned with MOBILE SCANNER

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон */төгрөгөөр/*

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	8,169,189,376.28	718,708,790.35
2	Борлуулалтын өртөг	8,272,609,676.14	290,115,117.67
3	Нийт ашиг (алдагдал)	(103,420,299.86)	428,593,672.68
4	Түрээсийн орлого	3,076,414,201.59	2,627,275,147.64
5	Хүүний орлого	1,084,981,648.04	1,140,055,216.12
8	Бусад орлого	387,006,368.05	24,862,426.18
9	Борлуулалт, маркетингийн зардал	466,388,761.66	36,923,747.54
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,004,888,370.11	2,078,556,760.04
11	Санхүүгийн зардал	17,310,340,061.10	15,634,849,741.04
12	Бусад зардал	791,219,960.09	150,800,254.55
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	452,016.81	(150,289.15)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	670,000.00	(3,888,294.34)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(16,126,733,218.33)	(13,684,382,624.04)
19	Орлогын татварын зардал	108,498,164.80	148,720,136.97
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(16,235,231,383.13)	(13,833,102,761.01)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(16,235,231,383.13)	(13,833,102,761.01)
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон */төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний дүн	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**88,000.00**	**17,000,270.98**	**60,998,787.00**	**66,698,133,880.00**	**(105,166,643,764.34)**	**(38,390,422,826.36)**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-	-	(2,141,460,726.93)	(2,141,460,726.93)
Залруулсан үлдэгдэл	88,000.00	17,000,270.98	60,998,787.00	66,698,133,880.00	(107,308,104,491.27)	(40,531,883,553.29)
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	(16,235,231,383.13)	(16,235,231,383.13)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	(670,000.00)	-		(670,000.00)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**88,000.00**	**17,000,270.98**	**60,328,787.00**	**66,698,133,880.00**	**(123,962,598,958.06)**	**(57,187,048,020.08)**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө,	-	-	-	-	1,010,738,165.21	1,010,738,165.21

Scanned with MOBILE SCANNER

алдааны залруулга						
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,000.00	17,000,270.98	60,328,787.00	66,698,133,880.00	(122,951,860,792.85)	(56,176,309,854.87)
Тайлант үеийн үр дүн			-		(13,833,102,761.01)	(13,833,102,761.01)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**88,000.00**	**17,000,270.98**	**60,328,787.00**	**66,698,133,880.00**	**(136,782,602,350.86)**	**(70,007,051,412.88)**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон *төгрөгөөр/*

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**		
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**8,667,941,516.92**	**8,234,351,273.80**
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого	8,627,821,727.92	8,209,873,302.59
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	608,760.00	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	12,380,829.00	6,375,620.21
1.1.6	Бусад мөнгөн орлого	27,130,200.00	18,102,351.00
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**3,115,683,945.64**	**20,306,054,924.10**
1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	861,589,288.00	1,061,140,402.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	276,221,770.86	312,220,690.08
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,025,642,467.99	2,455,876,561.71
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	17,071,263.48	26,581,902.69
1.2.5	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	926,599.10	127,272.73
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	15,342,499,999.99
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	184,960,941.51	518,460,866.54
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,551,902.21	8,671,902.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	746,719,712.49	580,475,326.36
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**5,552,257,571.28**	**(12,071,703,650.30)**
2	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**		
2.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**290,635,637.99**	**1,052,741,269.39**
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	290,635,637.99	1,052,741,269.39
2.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**4,500,000.00**	**-**
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,500,000.00	-
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**286,135,637.99**	**1,052,741,269.39**
3	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**		
3.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**186,552,816,613.81**	**5,023,648,970.53**
3.1.1	Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	186,552,364,597.00	5,022,666,308.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	452,016.81	982,662.53
3.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**187,416,506,647.91**	**1,201,132,951.68**
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	187,416,506,647.91	1,200,000,000.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		1,132,951.68

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДСАН САНАЛ ДҮГНЭЛТ
MOBILE SCANNER

3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(863,690,034.10)**	**3,822,516,018.85**
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**4,974,703,175.17**	**(7,196,446,362.06)**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**6,797,700,964.41**	**11,772,404,139.58**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**11,772,404,139.58**	**4,575,957,777.52**

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон */мянган төгрөгөөр/*

№	Үзүүлэлтүүд	2022 он	2023 он		Зөрүү	Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					
1	**Нийт орлого**	**8,958,577.3**	**22,176,346.8**	**13,853,729.4**	**(8,322,617.4)**	**62.5**
1.1	Борлуулалтын орлого	2,259,238.4	1,446,569.6	1,135,162.0	(311,407.6)	78.5
1.2	Солонго-1,2 төслийн техникийн хяналтын орлого	-	4,467,131.4	-	(4,467,131.4)	-
1.3	Түрээсийн орлого	5,296,254.3	5,503,017.0	5,851,977.8	348,960.8	106.3
1.4	Түрээсийн санд шилжсэн орон сууцны төсвөөс авах төлбөр	5,000,000.0	5,000,000.0	5,000,000.0	-	100.0
1.5	ХОХАГ-т байгууллагын төлбөрийн орлого	25,456.6	4,744,596.4	31,099.5	(4,713,496.9)	0.7
1.6	Түрээслээд өмчлөх үйл ажиллагааны орлого	1,059,862.1	745,859.1	1,199,196.5	453,337.4	160.8
1.7	Бусад орлого	317,765.9	269,173.3	636,293.7	367,120.4	236.4
2	**Нийт зардал**	**9,798,589.6**	**22,169,869.9**	**18,919,534.7**	**(3,250,335.2)**	**85.3**
2.1	Ерөнхий ба удирдлагын зардал	1,035,307.3	2,967,835.6	2,979,224.8	11,389.2	100.4
2.2	Үйл ажиллагааны бус зардал	16,029.9	13,920.0	21,573.0	7,653.0	155.0
2.3	Санхүүгийн зардал	8,732,702.4	14,687,680.4	15,258,431.5	570,751.1	103.9
2.4	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	14,550.0	1,157,255.7	660,305.4	(496,950.3)	57.1
2.5	Солонго-1,2 төслийн нэгжийн Ерөнхий ба удирдлагын зардал	-	3,343,178.2	-	(3,343,178.2)	-
3	**Татварын өмнөх ашиг**	**(840,012.3)**	**6,476.9**	**(6,758,824.4)**	**(6,765,301.3)**	**-**
4	**Цэвэр ашиг (алдагдал)**	**(840,012.3)**	**5,829.2**	**(6,758,824.4)**	**(6,764,653.6)**	**-**
5	Төсвийн төлбөрт нийт дүн	544,423.2	570,992.0	2,499,058.6	1,928,066.6	437.7
	а/ Орлогын татварт	76,048.6	23,000.0	30,533.7	7,533.7	132.8
	б/ НӨАТ	-	-	165,632.6	165,632.6	-
	в/ НДШ	276,380.5	183,518.8	182,926.4	(592.4)	99.7
	г/ Хувь хүний орлогын албан татвар	87,384.9	68,000.0	51,953.8	(16,046.2)	76.4

Scanned with MOBILE SCANNER

	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	14,502.2	14,502.2	14,502.2	-	100.0
	е/ Гаалийн татвар	-	-	1,766,661.0	1,766,661.0	-
	ё/ Тээврийн хэрэгслийн татвар	470.6	860.0	607.1	(252.9)	70.6
	ж/ Бусад татвар (газрын төлбөр)	89,636.4	281,111.0	286,241.8	5,130.8	101.8
6	Төрийн өмчийн ногдол ашигт	-	-	-	-	-
7	Нийт ажиллагсдын тоо	54	50	50	-	100.0
8	Нийт цалингийн сан	1,171,357.0	1,578,220.4	1,160,739.8	(417,480.6)	73.5
9	Нэг ажилтны дундаж цалин	1,807.6	2,630.4	1,934.6	(695.8)	73.5
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.1	1.0	1.4	0.4	140.1
11	**Хөрөнгө оруулалт**	**274,583.6**	**985,100.0**	**24,384.0**	**(960,716.0)**	**2.5**
	а/ Үндсэн хөрөнгө худалдан авалтын зардал	25,284.9	166,100.0	24,384.0	(141,716.0)	14.7
	б/ Солонго-1,2 төслийн үндсэн хөрөнгө худалдан авалт	-	819,000.0	-	(819,000.0)	-
	в/ Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлын зардал	249,298.7	-	-	-	-
12	**Нийт авлага**	**114,823,582.5**	**70,767,943.0**	**109,486,625.9**	**38,718,682.9**	**154.7**
	а/ Түрээсийн орон сууцны авлага	62,344,944.5	57,344,944.5	57,344,944.5	-	100.0
	б/ ХОХАГ-т гэрээтэй байгууллагаас авах авлага	18,131,488.4	13,422,998.5	18,124,182.7	4,701,184.2	135.0
	в/ Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн авлага	32,792,787.9	-	32,792,787.9	32,792,787.9	-
	г/ Барилгын санхүүжилтийн авлага	1,194,124.1	-	1,174,199.6	1,174,199.6	-
	д/ Компани хоорондын авлага	50,511.2	-	50,511.2	50,511.2	-
	е/ Бусад авлага	309,726.4	-	-	-	-
13	**Нийт өр төлбөр**	**262,273,320.7**	**223,968,546.1**	**266,617,173.5**	**42,648,627.4**	**119.0**
	Богино хугацаат өр төлбөр.	**242,624,016.5**	**201,029,241.9**	**243,057,722.2**	**42,028,480.3**	**120.9**
	1. Зээл /Хөдөлгөөнт тоног төхөөрөмж/	25,649,932.4	-	25,649,932.4	25,649,932.4	-
	2. Өглөг /Сангийн яам/	36,474,084.1	38,233,001.5	36,907,789.8	(1,325,211.7)	96.5
	3. Үнэт цаасны өглөг	180,500,000.0	162,796,240.4	180,500,000.0	17,703,759.6	110.9
	Урт хугацаат өр төлбөр	**19,649,304.2**	**22,939,304.2**	**23,559,451.3**	**620,147.1**	**102.7**
	1. Түрээсийн орон сууцны зээл	18,200,000.0	22,000,000.0	22,000,000.0	-	100.0
	2. Барилгын чанарын баталгааны өглөг	1,449,304.2	939,304.2	1,559,451.3	620,147.1	166.0

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААР/ЛА/ТТАЙ САНАЛ АУДИТ

Scanned with MOBILE SCANNER

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК нь эрхэм зорилгоо "Хүн амыг хямд өртөгтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйл ажиллагааг явуулахад оршино" гэж тодорхойлсон байна.

Компанийн үндсэн зорилт нь Монгол Улсын хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах бие даасан хуулийн этгээд гэж байгууллагын дүрэмд заасан байна.

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн өмнөөс Монгол Улсын нутаг дэвсгэрт орон сууц бариулах, худалдан борлуулах;
- Төрийн өмчийн түрээсийн орон сууцыг эзэмшиж ашиглах, түрээслүүлэх, хувьчлах, өмчлүүлэх;
- Орон сууцны хотхон, хороолӧлтой цогцоор нь баригдсан арилжааны зориулалттай барилга байгууламж, талбайг ашиг олох зорилгоор түрээслүүлэх, худалдан борлуулах;
- Гадаад дотоодын компани, аж ахуйн нэгж, байгууллагатай орон сууц, үл хөдлөх хөрөнгийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор гэрээгээр болон хамтарсан аж ахуйн нэгж байгуулах зарчмаар хамтран ажиллаж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх;
- Голч орлогоос доош орлоготой иргэдэд чиглэсэн орон сууц санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, урт хугацааны, хямд түрээсийн орон сууцны менежментийг хэрэгжүүлэх;
- Иргэдийг орон сууцжуулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын судалгаа, төслийг хэрэгжүүлэх боломж үндэслэлийг судлан, техник эдийн засгийн үндэслэл, төсөл хэрэгжүүлэх талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх;
- Бүх төрлийн эх үүсвэрээр баригдсан болон баригдаж буй орон сууцны тодорхой хэсгийг худалдан авч түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх;
- Хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгийг зах зээлээс санхүүжилтийн эх үүсвэр татах ажлыг зохион байгуулж, газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгөд хөрөнгө оруулалт хийж, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Дэд бүтэц болон нийгмийн салбарын барилга байгууламж байгуулах ажилд захиалагчийн үүрэг гүйцэтгэх, хяналт тавих;
- Хууль тогтоомжид нийцүүлэн компанийн бонд, хувьцаанд хөрвөх өрийн хэрэгсэл гаргах, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;
- Томоохон орон сууцны төсөл, хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд концессын гэрээгээр хэрэгжүүлэх;
- Нийслэл болон орон нутагт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгогдсон газрыг эзэмших, ашиглах, концессын гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулалт татаж хэрэгжүүлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай, өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Scanned with MOBILE SCANNER

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 200 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах ..." гэсэн заалттай нийцэж байна.

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүн байна.

Тайлант хугацаанд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоол "Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай"

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант хугацаанд Барилга хот байгуулалтын яамны дотоод аудитын албанаас санхүүгийн хяналт шалгалт хийгээгүй байна. Дотоод аудитын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ
Scanned with MOBILE SCANNER

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,070.5 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,722,404.1	4,575,957.8	(7,196,446.3)
Авлага	53,321,068.0	52,214,590.9	(1,106,477.1)
Бараа материал	10,746,075.6	11,314,465.2	568,389.5
Урьдчилж төлсөн зардал	5,161.6	-	(5,161.6)
Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгө	88,664,294.8	88,374,179.6	(290,115.1)
Үндсэн хөрөнгө	68,559,214.7	68,518,491.8	(40,722.9)
Нийт хөрөнгө	**233,068,218.9**	**224,997,685.3**	**(8,070,533.6)**
Өр төлбөр	290,255,266.9	295,004,736.7	4,749,469.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	(57,187,048.0)	(70,007,051.4)	(12,820,003.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**233,068,218.9**	**224,997,685.3**	**(8,070,533.6)**

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгө, дансны өглөг, эздийн өмчийн дансууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 7,196.4 сая төгрөгөөр буурсан нь 2022 оны 12 дугаар сард Хөгжлийн банкны өрийг жилийн 8.5 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, 1.0 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 1.0 сая ширхэг 180,500.0 сая төгрөгийн хаалттай бонд гаргаж, 6 сар тутам бондын хүүгийн төлбөрийг төлөх үнэт цаасны бүртгэлийн гэрээний дагуу тайлант оны эцэст 7,692.3 сая төгрөгийн хүүгийн төлбөрийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,106.4 сая төгрөгөөр буурсан нь өмнөх аудитын зөвлөмжийн дагуу хийсэн залруулгаас шалтгаалжээ. Нийт авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай, 2014-2016 онуудад үүссэн 77 аж ахуйн нэгж, 960 иргэнээс авах нийт 21,407.4 сая төгрөг, 2017 онд үүссэн, Монгол Улсын Хөгжлийн банкнаас Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ-ын "Хөдөлгөөнт цогцолбор" төслийн зориулалттай, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх зээлтэй холбоотой үүсэн 30,595.5 сая төгрөгийн авлагууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,314.5 сая төгрөг болж 568.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Солонго 1 төслийн бэлтгэл ажилд 206.4 сая төгрөг, Эко яармагийн газар

Scanned with MOBILE SCANNER

челеелехтэй холбоотой 310.1 сая төгрөг, орон нутгийн шинэ төсөлд 29.4 сая төгрөг, хангамжид 22.5 сая төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Борлуулах зорилгоор байгууллагын эзэмшилд байгаа 1,641 ширхэг зоорь, гараж, орон сууц, үйлчилгээний төвийн талбай бүхий нийт 88,374.2 сая төгрөгийн хөрөнгө байна. Тайлант хугацаанд 119.0 сая төгрөгийн 2 орон сууц, 171.1 сая төгрөгийн 14 автозогсоол, нийт 16 ширхэг 290.1 сая төгрөгийн хөрөнгийг иргэдэд шилжүүлснээс борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө буурсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 68,518.5 сая төгрөг болж 40.7 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2023 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн 448 дугаар тогтоолоор 76 нэрийн 56.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 14.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон, мөн өдрийн 461 дугаар тогтоолоор 84 нэрийн нийт 193.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 8.7 сая төгрөгийн камер, 14.1 сая төгрөгийн дуран, нийт 22.8 сая төгрөгийн техөөрөмжийг худалдан авч, тайлант онд 94.3 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,746.1 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2016 оны "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 38, 169 дүгээр тогтоолуудад Төрийн орон сууцны корпорац ТӨХХК-ийн захиалгаар Улаанбаатар хот болон орон нутагт барьж ашиглалтад оруулсан 1,289 айлын орон сууцны барилгыг барихад зарцуулсан Хөгжлийн банкны зээлийн төлбөр болох 82,344.9 сая төгрөгийг улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусган шийдвэрлэх арга хэмжээний хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК нь Хөгжлийн банкны зээлийн үндсэн төлбөрт төлөхөөр 6 жилийн хугацаатай, хүүгүй дамжуулан зээлдүүлэх гэрээг Барилга, хот байгуулалтын яамтай байгуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх зээлийн санхүүжилтийн эх үүсвэрт жил бүр 5,000.0 сая төгрөгийг тусгаж, 2019-2023 онуудад нийт 25,000.0 сая төгрөгийг төлөвлөж, 2023 онд 5,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, эргэн төлөх хуваарийн дагуу зээлийг төлснөөр оны эцэст 22,000.0 сая төгрөг болсноос шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 12,820.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 13,833.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, 1,010.7 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн залруулга хийсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 570 дугаар тогтоолоор Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 22,176.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 22,169.9 сая төгрөгөөр, 5.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 985.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ
Scanned with MOBILE SCANNER

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 он	2023 он		Зөрүү	Хувь
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт							
1	Борлуулалтын орлого	мян.төг	2,259,238.4	1,446,569.6	1,135,162.0	(311,407.6)	78.5
2	Солонго-1,2 теслийн техникийн хяналтын орлого	мян.төг	-	4,467,131.4	-	(4,467,131.4)	-
3	Түрээсийн орлого	мян.төг	5,296,254.3	5,503,017.0	5,851,977.8	348,960.8	106.3
4	Түрээсийн санд шилжсэн орон сууцны төсвөөс авах төлбөр	мян.төг	5,000,000.0	5,000,000.0	5,000,000.0	-	100.0
5	ХОХАГ-т байгууллагын төлбөрийн орлого	мян.төг	25,456.6	4,744,596.4	31,099.5	(4,713,496.9)	0.7
6	Түрээслээд өмчлөх үйл ажиллагааны орлого	мян.төг	1,059,862.1	745,859.1	1,199,196.5	453,337.4	160.8
7	Бусад орлого	мян.төг	317,765.9	269,173.3	636,293.7	367,120.4	236.4
8	Нийт орлого	мян.төг	9,798,589.6	22,176,346.8	13,853,729.5	(8,322,617.3)	62.5
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	8,862,748.4	21,019,869.9	17,732,409.9	(3,287,460.0)	84.3
	Дансны хүү, бусад орлого	мян.төг	935,841.2	1,150,000.0	1,187,124.8	37,124.8	103.2
9	Нийт зардал	мян.төг	9,798,589.6	22,169,869.9	18,919,534.7	(3,250,335.2)	85.3
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	1,035,307.3	2,967,835.6	2,979,224.8	11,389.2	100.4
10	Татварын өмнөх ашиг	мян.төг	(840,012.3)	6,476.9	(6,758,824.4)	(6,765,301.3)	-
11	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(840,012.3)	5,829.2	(6,758,824.4)	(6,764,653.6)	-
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	274,583.6	985,050.0			

Гүйцэтгэлээр 13,853.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 18,919.5 сая төгрөгийн зардал гарган, 6,758.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 13,853.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 8,322.6 сая төгрөг буюу 37.5 хувиар дутуу биелсэн нь Солонго-1,2 теслийн ажил эхлээгүй, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээт байгууллагуудаас төлбөр орж ирээгүйгээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 18,919.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 3,250.3 сая төгрөг буюу 14.7 хувиар дутуу, зардлыг хэмнэж ажилласан байна.

Тайлант онд алдагдал 6,758.8 сая төгрөг болж, төлөвлөгөөг хангаж ажиллаагүй нь төлөвлөсөн төсөл хөтөлбөр хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

ТӨБЗГ нь байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлахдаа мөнгөн суурьт үндэслэн боловсруулж байгаа нь аккруэл суурьтай бэлтгэж байгаа ашиг, алдагдалтай нийцэхгүй, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бодитой илэрхийлж чадахгүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2023 онд ногдол ашиг төлөрүүлээгүй байна.

Scanned with MOBILE SCANNER

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх зөвлөмж өгснийг тусгасан болно.

Аудитыг ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-ийн аудитор Д.Сугар, туслах аудитор Б.Энхчимэг нар гүйцэтгэж, аудитын менежер Ж.Эрдэнэбилэг, захирал Д.Энхбаатар нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор М.Лхагвасүрэн, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 1/96 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 28,953.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 289.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант хугацаанд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 274.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 36.5 сая төгрөг, ашиглалтын зардлыг 5.0 сая төгрөг, гадаад, дотоод томилолтын зардлыг 11.8 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын зардлыг 16.6 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Scanned with MOBILE SCANNER

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 26 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 158 мэдээлэл байршуулахаас 151 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө менгө зарцуулах шийдвэрийн 287.5 сая төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.3.2 "төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт", 6.3.3 "төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар", 6.4.1 "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт" заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, дутуу байршуулсан зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тус байгууллага нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй 23.5 сая төгрөгийн өртөгтэй 3 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг 2021 онд шинэчлэгдсэн Хөдөлмөрийн тухай хуулийн заалтуудтай нийцүүлэн шинэчлээгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 12.3 "Хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний аливаа зохицуулалт нь ажилтны эрхийг хууль

Scanned with MOBILE SCANNER

тогтоомжид зааснаас дордуулсан бол тухайн зохицуулалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг 2021 онд шинэчлэгдсэн Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар үндсэн хөрөнгө, төлөгдөөгүй авлага, барагдуулаагүй өр төлбөрийн нөхцөл байдалтай танилцаж, жилийн эцсийн аудитын аудитын эрсдэлийг тодорхойлсон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 55,867.0 сая төгрөгийн зөрчил арилгах 1 төлбөрийн акт, 6 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийн хэрэгжилт 31.7 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	30,800.0	1	18,480.0	60.0
Албан шаардлага	6	52,279,738.5	6	-	16.7
Зөвлөмж	3	1,829,753.4	3	-	50.0
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	2	1,726,734.6	2	-	-
Нийт дүн	**12**	**55,867,026.5**	**12**	**18,480.0**	**31.7**

Өмнөх аудитаар тогтоосон эко яармаг төслийн түр суурьшуулах хөрөнгийг илүү олгосонтой холбоотой 1 төлбөрийн акт, гэрээгээ цуцалсан иргэнд байр борлуулсан, авлага барагдуулах, хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг шилжүүлэх, 3 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Өмнөх аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршсан бараа, ажил үйлчилгээг захиалгаар худалдан авсан эсэхийг дараагийн аудитаар нарийвчлан үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

Ажилчдаас авах авлагыг 0.3 сая төгрөгөөр илүү төлөлт хийснийг өглөгийн дансанд шилжүүлэн залруулсан.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Scanned with MOBILE SCANNER

Аудитаар нийт 82,708.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 2.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 82,647.9 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 58.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, 1 асуудалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар илэрсэн 82,708.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 289.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт:

Ашиг сонирхлын зөрчлийн улмаас ажлаас халагдсан ажилтанд нэг удаагийн 2.9 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.6 "Ажил олгогч ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд түр ажиллаж байсан ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болоход энэ хуулийн 82.1-д заасан тэтгэмжийг олгох үүрэг хүлээхгүй." заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Хариуцлага тооцох албан шаардлага

Өмнөх аудитаар тогтоосон 1 төлбөрийн акт, 3 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна", 19.2 "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Олон жилийн насжилттай, 2014-2016 онуудад үүссэн 77 аж ахуйн нэгж, 960 иргэнээс авах нийт 21,407.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Scanned with MOBILE SCANNER

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт:

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК нь 37 аж ахуйн нэгж, 1,540 иргэнд төлөх нийт 30,641.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" заалттай нийцэхгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр үүссэн шалтгаан, нөхцөл байдлыг хянаж, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулах, цаашид төсвийг зохистой удирдаж, өр, үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Илрүүлэлт:

Монгол Улсын Хөгжлийн банкнаас Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ-ын "Хөдөлгөөнт цогцолбор" төслийн зориулалттай, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх 7.1 сая ам.долларын зээлийг 2017 онд авч, уг зээлтэй холбоотойгоор тус байгууллага нь өнөөдрийн байдлаар Гаалийн ерөнхий газарт татварын 3,340.6 сая төгрөг, тэмдэгтийн хураамж 131.1 сая төгрөг, хүү торгуулийн алданги 1,473.9 сая төгрөг нийт 4,945.6 сая төгрөгийн алдагдал хүлээж, Шүүхийн шийдвэрээр Хөгжлийн банканд төлөх 25,649.9 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Илрүүлэлт:

ХААН банканд 2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай, жилийн 11.53 хувийн хүүтэйгээр 200.0 сая төгрөгийн хадгаламж нээсэн, хугацааны эцэст хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлснээр 1,285.0 сая төгрөгт хүрсэн байна. ХААН банктай байгуулсан хадгаламжийн гэрээний 2.17 "Хадгаламжийн гэрээг шууд сунгах - үгүй" нөхцөлтэй байсан боловч банк харилцагчийн зөвшөөрөлгүйгээр хадгаламжийн хугацааг сунгасны улмаас нийт хадгаламжид хадгалуулсан мөнгөө эргэж татах үед банк хадгаламжийн хугацааг цуцалсанд тооцон 3.4 сая төгрөгийн хадгаламжийн хүүг илүү суутган авсан байна.

Энэ нь Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "хадгалуулагчийн тавьсан анхны шаардлагаар хадгаламжийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу түүний

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ
Scanned with MOBILE SCANNER

хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хадгаламжийн хүү төлөх", 14.2.4 "хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв бодож, олгох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Илрүүлэлт:

Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл зэрэг нийт 72 нэр төрлийн 58.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", НББОУС 17-д "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, өртгийг бодитой тогтоож бүртгэлд тусгах талаар зохих байгууллагад хандан шийдвэрлүүлэх.

Дээрх зөрчлийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Scanned with MOBILE SCANNER

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилчдаас авах авлагыг 0.3 сая төгрөгөөр илүү төлүүлсэн байна.	1	323.5			1	323.5	1	323.5				
Дүн	**1**	**323.5**			**1**	**323.5**	**1**	**323.5**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Олон жилийн насжилттай, 2014-2016 онуудад үүссэн 77 аж ахуйн нэгж, 960 иргэнээс авах нийт 21,407.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	21,407,442.9			1	21,407,442.9						
Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл зэрэг нийт 72 нэр төрлийн	1	58,043.4					1	58,043.4				

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Scanned with MOBILE SCANNER

58.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.												
Тус байгууллага нь 37 аж ахуйн нэгж, 1,540 иргэнд төлөх нийт 30,641.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	30,641,514.6			1	30,641,514.6						
МУ-ын Хөгжлийн банкнаас Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ-ын "Хөдөлгөөнт цогцолбор" төслийн зориулалттай, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх зээлийг 2017 онд авч, уг зээлтэй холбоотойгоор тус байгууллага нь өнөөдрийн байдлаар нийт 4,945.6 сая төгрөгийн татвар, тэмдэгтийн хураамж торгууль, алдагдал хүлээж, Шүүхийн шийдвэрээр Хөгжлийн банканд төлөх 25,649.9 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна.	1	30,595,553.9			1	30,595,553.9						
Ашиг сонирхлын зөрчлийн улмаас ажлаас халагдсан ажилтанд нэг удаагийн 2.9 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.	1	2,890.0	1	2,890.0								
ХААН банканд байршуулсан хадгаламжийн хугацааг цуцалсанд	1	3,442.7			1	3,442.7						

Scanned with MOBILE SCANNER

тооцон 3.4 сая төгрөгийн хадгаламжийн хүүг илүү суутган авсан байна.												
Өмнөх аудитаар тогтоосон 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн байна.	1	-							1	-		
Дүн	**7**	**82,708,887.5**	**1**	**2,890.0**	**4**	**82,647,954.1**	**1**	**58,043.4**	**1**	**-**		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 158 мэдээллээс 154 мэдээллийг байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, төсөв, өмч, хөрөнгө менгө зарцуулах шийдвэрийн 287.5 сая төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	1	-		
Дүн	**1**	**-**	**1**	**-**		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тус байгууллага нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэлгүй, 23.5 сая төгрөгийн өртөгтэй 3 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.	1	-	1	-		
Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг 2021 онд шинэчлэгдсэн Хөдөлмөрийн тухай хуулийн заалтуудтай нийцүүлэн шинэчлээгүй байна.	1	-			1	-
Дүн	**2**	**-**	**1**	**-**	**1**	**-**
Нийт дүн	**3**	**-**	**3**	**-**	**1**	**-**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Scanned with MOBILE SCANNER

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 дугаар сарын 15 № 89/А0150458 Улаанбаатар хот

СМАГ-2024/104/НА-ЦА-ТОА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашиг сонирхлын зөрчлийн улмаас ажлаас халагдсан ажилтанд нэг удаагийн 2,890,000.00 /хоёр сая найман зуун ерэн мянган/ төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хулийн 82 дугаар зүйлийн 82.6 "Ажил олгогч ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд түр ажиллаж байсан ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болоход энэ хуулийн 82.1-д заасан тэтгэмжийг олгох үүрэг хүлээхгүй." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зөрчил гаргаж ажлаас халагдсан ажилтанд олгосон 2,890,000.00 /хоёр сая найман зуун ерэн мянган/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Нямдулам/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр. Утас 51-264230

Z:\Akt 2024\0315 SNAG-4.Docx

01090392
Scanned with CamScanner
MOBILE SCANNER

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 476/А0150458 Улаанбаатар хот

СМА(-2024/104/АА-СТД-ТОА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компани нь өмнөх оны аудитаар тогтоосон эко яармаг төслийн түр суурьшуулах хөрөнгийг илүү олгосонтой холбоотой 2023 оны 132/А0150055 дугаартай төлбөрийн акт, гэрээгээ цуцалсан иргэнд байр борлуулсан, авлага барагдуулах, хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг шилжүүлэхтэй холбоотой хүргүүлсэн 2023 оны 495/А0150055, 497/А0150055, 498/А0150055 дугаартай 3 албан шаардлагыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна", 19.2 "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Өмнөх онд хүргүүлсэн албан шаардлага, төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлээгүй буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — С.НАЦАГДОРЖ
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0315 SNAG-19.Docx

6201081111

Scanned with MOBILE SCANNER

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 477/А0150458 Улаанбаатар хот

СНХГ-2024/104/НА-СТА-ТОД

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд мэдээлбэл зохих 158 мэдээлэл байршуулахаас 151 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, емч, хөрөнгө менеж зарцуулах шийдвэрийн 287,500,000.00 /хоёр зуун наян долоон сая таван зуун мянган/ төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.3.2 "төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт", 6.3.3 "төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар", 6.4.1 "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт" заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлэхгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлэхгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд үнэн зөв мэдээлэхгүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Нямдулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — С.НАЦАГДОРЖ

ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

0001081109

Scanned with MOBILE SCANNER

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 478/А01580458 Улаанбаатар хот

СПА-2024/НА-СТА-ТОА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй 23,534,000.00 /хорин гурван сая таван зуун гучин дөрвөн мянган/ төгрөгийн өртөгтэй 3 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.", 14.4. "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/, Ерөнхий нягтлан бодогч / Н.Нямдулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

Z:\Alban Shaardlaga\2024\0315 SNAG-19.Docx

0001081107

Scanned with MOBILE SCANNER

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 479/А0150458 Улаанбаатар хот

СМАГ-2024/104/ПА-СТА-ТОА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХААН банканд 2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай, жилийн 11.53 хувийн хүүтэйгээр 200,000,000.00 /хоёр зуун сая/ төгрөгийн хадгаламж нээсэн, хугацааны эцэст хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлснээр 1,285,000,000.00 /нэг тэрбум хоёр зуун наян таван сая/ төгрөгт хүрсэн байна. ХААН банктай байгуулсан хадгаламжийн гэрээний 2.17 "Хадгаламжийн гэрээг шууд сунгах-үгүй" нөхцөлтэй байсан боловч банк хариуцагчийн зөвшөөрөлгүйгээр хадгаламжийн хугацааг сунгасны улмаас нийт хадгаламжид хадгалуулсан мөнгөө эргэж татах үед банк хадгаламжийн хугацааг цуцалсанд тооцон 3,442,703.80 /гурван сая дөрвөн зуун дөчин хоёр мянга долоон зуун гурван/ төгрөгийн хадгаламжийн хүү илүү суутган авсан байна.

Энэ нь Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "хадгалуулагчийн тавьсан анхны шаардлагаар хадгаламжийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хадгаламжийн хүү төлөх", 14.2.4 "хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв бодож, олгох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулж, илүү суутгасан хүүг буцаан төлөүүлж зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/, Ерөнхий нягтлан бодогч / Н.Нямдулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — С.НАЦАГДОРЖ
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Д.ЭНХБААТАР

Scanned with MOBILE SCANNER

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 480/А0150458 Улаанбаатар хот

СМАГ-2024/904/НА-СТА-ТОА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Хөгжлийн банкнаас Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ-ын "Хөдөлгөөнт цогцолбор" төслийн зориулалттай, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх 7.1 сая ам.долларын зээлийг 2017 онд авч, уг зээлтэй холбоотойгоор тус байгууллага нь өнөөдрийн байдлаар Гаалийн ерөнхий газарт татварын 3,340,612,628.89 /гурван тэрбум гурван зуун дөчин сая зуруун зуун арван хоёр мянга зургаан зуун хорин найман/ төгрөг, тэмдэгтийн хураамж 131,125,125.54 /нэг зуун гучин нэгэн сая нэг зуун хорин таван мянга нэг зуун хорин таван/ төгрөг, хүү торгуулийн алданги 1,473,883,727.56 /нэг тэрбум дөрвөн зуун далан гурван сая найман зуун наян гурван мянга долоон зуун хорин долоон/ төгрөг, нийт 4,945,621,481.99 /дөрвөн тэрбум есөн зуун дөчин таван сая зургаан зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун наян нэгэн / төгрөгийн алдагдал хүлээж, Шүүхийн шийдвэрээр Хөгжлийн банканд төлөх 25,649,932,438.09 /хорин таван тэрбум зургаан зуун дөчин есөн сая есөн зуун гучин хоёр мянга дөрвөн зуун гучин найман/ төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

5001081103
MOBILE SCANNER

1. Хөгжлийн банкнаас авсан зээлтэй холбоотойгоор үүсэн өр төлбөрийг барагдуулаагүй талаар дээд шатны төсөв захирагчид хандаж арга хэмжээ аваагүй, өр төлбөрийг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарируулэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/, Ерөнхий нягтлан бодогч / Н.Нямдулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР: С.НАЦАГДОРЖ

ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ: Д.ЭНХБААТАР

Scanned with MOBILE SCANNER

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 481/А01/50458 Улаанбаатар хот

СМАГ-2024/104/ПА-СГА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 37 аж ахуйн нэгж, 1,540 иргэнд төлөх нийт 30,641,514,597.77 /гучин тэрбум зургаан зуун дөчин нэгэн сая таван зуун арван дөрвөн мянга таван зуун ерэн долоон/ төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөр үүссэн шалтгаан, нөхцөл байдлыг хянаж, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төсвийг зохистой удирдаагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Нямдулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

Z:\Alban Shaardlaga\2024\0315 SMAG-19.Docx

01081101

Scanned with MOBILE SCANNER

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 482/А0150458 Улаанбаатар хот

СМАГ-2024/104/НА-СТА-ТОА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олон жилийн насжилттай, 2014-2016 онуудад үүссэн 77 аж ахуйн нэгж, 960 иргэнээс авах нийт 21,407,442,939.16 /хорин нэгэн тэрбум дөрвөн зуун долоон сая дөрвөн зуун дөчин хоёр мянга есөн зуун гучин есөн/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт[1] ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Нямдулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — С.НАЦАГДОРЖ
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0315 SMAG-19.Docx

0001081099
PDF MOBILE SCANNER